



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/125

Чингис хот

Хамтран ажиллах гэрээнд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 4 дүгээр зүйлийн 4.1.8, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн иргэдийг мэдээллээр хангах, нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг хангах, төрийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлах зорилгоор Монголын Үндэсний Сайтын Хөгжлийн Нэгдсэн Холбоо /МҮСХНХ/ Төрийн Бус Байгууллагатай гэрээний дагуу хамтран ажиллахад 6000000 /зургаан сая/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА